Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2016 оны 12 сарын 19-ны өдрийн 3674 дугаарт бүртгэв.

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2016 оны 12 сарын 07 өдөр Дугаар 98 Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.дэх заалт, тус Зохицуулах зөвлөлийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан тус Зохицуулах зөвлөлийн 2016 оны 83 тоот тогтоолын 1, 3, 4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Тусгай зөвшөөрлийн шинэчилсэн нөхцөл шаардлагыг тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хүргүүлэх, сурталчилан таниулах ажлыг зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Тусгай зөвшөөрлийн алба /Л.Хишигдулам/, Үнэ тарифын алба /Ж.Гэрэлчулуун/, Эрх зүй, мэдээлэл, захиргааны алба /Б.Доржбат/-нд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА Э.ПҮРЭВЖАВ

ГИШҮҮН Б. ЖИГЖИД

Ч. БАТТОГТОХ

С. ЧУЛУУНХУЯГ

Р. НЯМЖАВ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 98 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

ХУУЛБАР ҮНЭН
Огноо: 2016.12.07
Албаны дарга:
Бичиг хэргийн ажилтан:

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү нөхцөл, шаардлага нь ус хангамж, ариутгах татуургын чиглэл ээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгоход тавигдах нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй байдалд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Нөхцөл, шаардлага нь ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааг үйлчилгээний чанарын стандартын дагуу технологийн найдвартай, үр ашигтай ажиллах нөхцлөөр хангуулах зорилготой болно.

1.3 Нөхцөл, шаардлага нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актад нийцсэн байна.

Хоёр. Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахад тавигдах шаардлага

2.1 Үйл ажиллагааны чиглэл бүрээр шаардлагатай мэргэжлийн үндсэн ажилчдаар хангагдсан байх.

2.2 Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулах аж ахуйн нэгж нь санхүүгийн хувьд чадамжтай байх, Тусгай зөвшөөрөл шинээр авах хүсэлт гаргагч нь өмнөх онд алдагдалгүй ажилласан байх, үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах "Орон сууцны барилгын үйлчилгээ" стандартад заасан хөрөнгөтэй байх.

2.3 Тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахад хангагч байгууллагад хуримтлагдсан өр төлбөргүй байх эсвэл өр барагдуулах график, гэрээтэй байх.

2.4 Тусгай зөвшөөрөл сунгуулах Тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид ТЗЭ гэх/ нь байгууллагынхаа орлого болоогүй усны хэмжээг зөв тооцоолж, усны алдагдлыг бууруулсан байх.

2.5 Тусгай зөвшөөрөл хүссэн үйл ажиллагааны чиглэл бүрээр заагдсан тусгай шаардлагаас гадна салбарын хууль, тогтоомж болон эрх бүхий байгууллагаас батлан гаргасан норм, дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллах, үйлдвэрлэл, үйлчилгээ

эрхлэхэд шаардлагатай тусгай зориулалтын технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, гарч болзошгүй аваар, ослоос урьдчилан сэргийлэх нөөцтэй байх, машин механизмтай байх, эсвэл гэрээгээр болон түрээсээр авч ашиглах нөхцлийг бүрдүүлсэн байх зэрэг нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагуудад тавигдах нийтлэг шаардлага болно.

2.6 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдэд дор дурдсан шаардлагууд тавигдана.

2.6.1 Хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуурга, хэмжих хянах хэрэгслийн инженер, цахилгааны мэргэжлийн инженертэй байх, 300м3/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн байгууламжийг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн ус хангамж, ариутгах татуургын, цахилгааны мэргэжлийн ажилтан тус бүр нэгээс доошгүй байх;

б. Сантехникийн засварчин, цахилгаанчин, хянах, хэмжих хэрэгслийн засварчин, гагнуурчин зэрэг мэргэжлийн ажилчидтай байх;

в. Тухайлсан байгууламжийг эзэмших буюу ашиглах зөвшөөрөлтэй байх;

г. Ус хангамжийн эх үүсвэрийн харуул хамгаалалт нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн байх;

д. Тоног төхөөрөмж, технологийн ажиллагааны горим бүдүүвч, холбогдох стандартуудыг бүрдүүлсэн байх;

2.6.2 Ус олборлох, цэвэршүүлэх байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр:

а.Ус хангамж, ариутгах татуургын инженер, 2500 $м^3$/хоногоос дээш хүчин чадалтай ус хангамжийн байгууламжийн хувьд усны шинжилгээний лабораторитой байх, 300$м^3$/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн байгууламжийг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй байх;

б. Халдваргүйжүүлэх тоног төхөөрөмжийн засварчинтай байхаас гадна ус шинжилгээний лабораторитай бол мэргэжлийн ажилтантай байх;

в. Тухайлсан байгууламжийг эзэмших буюу ашиглах зөвшөөрөлтэй байх;

д. Ус цэвэршүүлэх технологийн ажиллагааны горим, техник технологи нь шаардлага хангасан, лабораторийн шинжилгээний дүн, мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй, усны чанарын стандартын шаардлага хангасан байх;

ХУУЛБАР ГЭЭН

Огноо: 2016.12.07

Албаны дарга:

Бичиг хэргийн ажилтан:

е. Ус хангамжийн эх үүсвэрийн ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэгч нь хэрэглэгчид нийлүүлж буй усны дээжийг өдөр бүр авч, лабораторийн шинжилгээ хийх бөгөөд ундны усны холбогдох стандартад нийцсэн усаар хангаж байх;

ж. Усан сангийн ариутгал халдваргүйжүүлэлтийг холбогдох стандартын дагуу хийх бөгөөд ариутгалын бодисын нөөцтэй байх;

2.6.3 Цэвэр ус дамжуулах, түгээх шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуургын инженертэй байх, 300м3/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн байгууламжийг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй байх;

б. Сантехникийн засварчин, гагнуурчинтай байх;

в. Технологийн ажиллагааны горим бүдүүвч, дэвсгэр зураг, техникийн тодорхойлолт зэргийг бүрдүүлсэн байх;

2.6.4 Орон сууцны доторхи цэвэр бохир усны шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуургын /сантехникийн/, дулаан хангамжийн мэргэжлийн инженер, ээлжийн диспетчер, 300м3/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн байгууламжийг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн ажилтан, ээлжийн диспетчер тус тус байх;

б. 300м3/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газраас бусад тохиолдолд 200 өрхийн дунд 1 сантехникийн засварчинтай байх;

в. Гагнуурчин, цахилгаанчинтай байх;

г. Шугам, сүлжээний схем, байршлын зураг, технологийн бүдүүвч, дэвсгэр зураг, ашиглалтад хүлээн авсан акт, гэрээ, техникийн тодорхойлолттой байх;

д. Сард борлуулж буй усны хэмжээ нь үйл ажиллагааг хэвийн, алдагдалгүй явуулах нөхцлийг хангасан байх;

е. Шинээр тусгай зөвшөөрөл авч буй байгууллагуудын хувьд айл өрхүүдийг 100% тоолууржуулсан байх;

ё. Тусгай зөвшөөрөл сунгуулах аж ахуйн нэгж байгууллагуудын хувьд айл өрх, аж ахуйн нэгжүүдийг 80-аас доошгүй хувь тоолууржуулсан байх буюу тоолууржуулалт хийх график, төлөвлөгөөтэй байх;

ж. Орон сууцны засвар үйлчилгээний талаар хэрэглэгчдийн гомдол санал хүлээн авах, шуурхай дуудлагын утас ажиллуулдаг байх;

ХУУЛБАР ҮНЭН

Огноо: 2016.12.07

Албаны дарга:

Бичиг хэргийн ажилтан:

з. Засвар үйлчилгээ явуулахад хүндрэлгүй, үйлчилгээ үзүүлэх объект нь ойролцоо байрлалд, хамгийн бага зардлаар чанартай, шуурхай үйлчилгээ үзүүлэх нөхцлийг хангасан байх;

2.6.5 Ус дамжуулах төвийн ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийн мэргэжлийн инженер тус бүр байх;

б. Сантехникийн засварчин, цахилгаанчин, гагнуурчинтай байх;

в. Байршлын зураг, технологийн ажиллагааны горим бүдүүвч, дэвсгэр зураг, техникийн тодорхойлолт, ашиглалтад хүлээн авсан акт зэргийг бүрдүүлсэн байх;

2.6.6 Бохир усны гаргалгааны, цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн инженертэй, 300м3/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн байгууламжийг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй байх;

б. Сантехникийн засварчинтай байх;

в. Холболтын болон байршлын зураг, технологийн ажиллагааны горим бүдүүвч, засвар үйлчилгээний график, дэвсгэр зураг, тодорхойлолт зэргийг бүрдүүлсэн байх;

2.6.7 Бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн инженер, 300м3/хон хүртэл усны хэрэглээтэй суурин газрын хувьд тухайн байгууламжийг ашиглах тусгайлан бэлтгэгдсэн ус хангамж, ариутгах татуургын мэргэжлийн ажилтан нэгээс доошгүй байх/, 2500 $м^3$/хоногоос дээш хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн хувьд лабораториттой байх;

б. Сантехник, тоног төхөөрөмжийн засварчин, гагнуурчин, цахилгаанчин, хэмжих хянах хэрэгслийн засварчин ажилчид тус бүр нэгээс доошгүй байхаас гадна ус шинжилгээний лабораториттай бол мэргэжлийн ажилтантай байх;

в. Тухайлсан байгууламжийг эзэмших буюу ашиглах зөвшөөрөл, бохир ус цэвэрлэгээний технологийн бүдүүвч, цэвэрлэгээний түвшин, гарах усны найрлага, лабораторийн шинжилгээний дүн, дүгнэлттэй байх;

2.6.8. Ус хангамж, ариутгах татуургын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээний чиглэлээр:

а. Ус хангамж, ариутгах татуургын болон мэргэжлийн зөвлөх буюу мэргэшсэн инженертэй байх,

ХЭЗУУДАЛ ҮНЭН
Огноо: 2016.12.07
Албаны дарга:
Бичиг хэргийн ажилтан:

б. Шаардлагатай тохиолдолд цахилгаан, хэмжих хянах хэрэгслийн мэргэжлийн инженер, химич-бактериологичтой байх;

в. Сантехникийн засварчин, гагнуурчинтай байх;

г. Засвар үйлчилгээний зориулалтын автомашин, автокран, эксоватор, зөөврийн гагнуурын аппарат, цэвэр, бохир ус шинжилгээний сууринболон зөөврийн лаборатори, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн нөөцтэй байх;

2.6.9. Хот, суурины ус түгээх байрны ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр:

а. Төвлөрсөн шугамын ус түгээх байрны хувьд сантехникийн засварчин, ус түгээгчтэй байх, хангагч байгууллагатай байгуулсан гэрээтэй байх;

б. Гүний ус түгээх байрны хувьд ус түгээгчтэй байх, мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт, ажлын байрны дүгнэлттэй байх;

в. Зөөврийн ус түгээх байрны хувьд ус түгээгчтэй байх, хангагч байгууллагатай байгуулсан гэрээтэй байх;

2.6.10. Зөөврийн ус хангамжийн үйлчилгээний чиглэлээр:

а. Сангиллын жолоочтой байх;

б. Ус зөөврийн зориулалтын автомашинтай байх;

2.6.11. Бохир усыг тусгай зориулалтын автомашинаар зөөвөрлөх үйлчилгээний чиглэлээр:

а. С ангилалын жолоочтой байх;

б. Бохир ус зөөврийн зориулалтын автомашинтай байх;

г. Бохир ус хаях цэгийг эрх бүхий байгууллагаар тогтоолгосон байх;

Гурав. Тусгай зөвшөөрөл, түүний хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

3.1 ТЗЭ нь тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө сунгуулах хүсэлтээ гаргаж, зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

3.2. Тусгай зөвшөөрлөө сунгуулах ТЗЭ нь үйл ажиллагааныхаа гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ийг жил бүр дүгнэж, ирүүлсэн байна.

3.3.Тусгай зөвшөөрлийг хуульд заасны дагуу 3 /гурав/ жилийн хугацаагаар олгох бөгөөд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн үр дүнг үндэслэн 5 /тав/ хүртэл жилийн хугацаагаар сунгана.

3.4. Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө тусгай зөвшөөрлийн материалаа бүрдүүлж ирээгүй бол гэрчилгээнд заасан хугацаанаас хойш тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцно.

3.5.Тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж байгууллага нь тусгай зөвшөөрлийн гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлсэн байна.

ХУУЛБАР ҮНЭН
Огноо: 2016.12.07
Албаны дарга:
Бичиг хэргийн ажилтан:

3.6.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай шийдвэрийн талаар шийдвэр гарснаас хойш хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.

- - - oOo - - -

ХЭЛТЭРАР
ҮНЭН
Огноо: 2016.12.07
Албаны дарга:
Бичиг хэргийн ажилтан: